



МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2024 ОНЫ ЭХНИЙ 5 САРЫН ГҮЙЦЭТГЭЛ

Монгол Улсын Их Хурлын <http://parliament.mn/c/pwyo> цахим хаягаар, эсхүл дараах QR кодыг ашиглан бусад танилцуулга, мэдээтэй танилцана уу.



УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ТӨСВИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл: 2,028.0 тэрбум төгрөгийн
нашигтай гарчээ. 2024 оны эхний 5 сарын гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн
тэнцвэржүүлсэн тэнцлийн ашиг өмнөх оны мөн үеэс 632.7 тэрбум төгрөгөөр,
төлөвлөсөн дунгээс 3,262.5 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Төсвийн орлогын хувьд: 2024 оны эхний 5 сарын гүйцэтгэлээр нэгдсэн
төсвийн тэнцвэржүүлсэн орлого 12,072.0 тэрбум төгрөг болж, орлогын
төлөвлөгөө 82.5 сая төгрөг буюу 0.7 хувиар дутуу биелсэн бол өмнөх оны
мөн үеэс 3,568.2 тэрбум төгрөг буюу 42.0 хувиар нэмэгдсэн байна.

- Төлөвлөгөөтэй харьцуулахад нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын төлөвлөгөө тайлант хугацаанд 99.2 хувийн гүйцэтгэлтэй гарчээ.
- Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого төлөвлөснөөс 92.5 сая төгрөгөөр дутуу биелсэн. Үүнд: Татварын орлого 1.3 хувь буюу 145.5 сая төгрөгөөр төлөвлөснөөс дутуу биелсэн бол татварын бус орлого 7.6 хувь буюу 53.0 сая төгрөгөөр давж биелсэн байна.
- Тайлант хугацаанд нийгмийн даатгалын орлого, нэмэгдсэн өргтийн албан татвар, тусгай зориулалтын орлого, гадаад үйл ажиллагааны орлого 3.4-12.2 хувиар төлөвлөснөөс давж биелсэн бол бусад төрлийн татварын орлого /орлогын албан татвар, хөрөнгийн албан татвар, онцгой албан татвар, бусад татвар, төлбөр, хураамж/ 0.5-7.1 хувиар төлөвлөснөөс дутуу биелсэн гүйцэтгэлтэй байна.
- Татварын бус орлогын төлөвлөгөө тайлант хугацааны гүйцэтгэлээр 53.0 сая төгрөг буюу 7.6 хувиар давж биелсэн нь хүү, торгуулийн орлого, төсөвт байгууллагын өөрийн орлого, түрээсийн орлого, газрын тосны орлого, бусад орлого 1.4-200 хувь давж биелснээс шалтгаалжээ.

Төсвийн нийт зарлагын хувьд: Нэгдсэн төсвийн нийт зарлага 2024 оны эхний 5 сарын гүйцэтгэлээр 10,043.9 тэрбум төгрөг болж, 3,344.9 тэрбум төгрөгийн дутуу зарцуулалттай буюу 75.0 хувийн гүйцэтгэлтэй гарчээ.

- Нэгдсэн төсвийн нийт зарлагын гүйцэтгэлийг тайлант хугацааны төлөвлөгөөтэй харьцуулахад 25.0 хувиар дутуу зарцуулагдаж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 41.3 хувиар буюу 2,935.5 тэрбум төгрөгөөр өссөн байна.
- Зээлийн үйлчилгээний төлбөр өнгөрсөн оны мөн үеэс 29.1 тэрбум төгрөгөөр өссөн бол тайлант хугацааны төлөвлөсөн дунгээс 148.5 тэрбум төгрөгийн дутуу гүйцэтгэлтэй гарсан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалт: Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардалд 2024 онд нийт 3,359.4 тэрбум төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ. 2024 оны эхний 5 сарын гүйцэтгэлээр 308.4 тэрбум төгрөгийг зарцуулж 99.5 хувийн гүйцэтгэлтэй гарчээ.


МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2024 ОНЫ ЭХНИЙ 5 САРЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 2,028.0 тэрбум төгрөгийн ашигтай гарчээ.

1. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл

Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусlamжийн дүн 2024 оны эхний 5 сарын гүйцэтгэлээр 12,072.0 тэрбум төгрөг, нийт зарлага ба эргэж төлөгдхөн цэвэр зээлийн хэмжээ 10,043.9 тэрбум төгрөг болж, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 2,028.0 тэрбум төгрөгийн ашигтай гарчээ. Тайлант хугацаан дахь нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл өмнөх оны мөн үеэс 632.7 тэрбум төгрөгөөр, төлөвлөснөөс 3,252.5 тэрбум төгрөгөөр тус тус сайжирсан байна.

График 1. Нэгдсэн төсвийн гүйцэтгэл /тэрбум төгрөгөөр/



Тайлант хугацаанд нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого өнгөрсөн оны мөн үеэс 42.0 хувь буюу 3,568.2 тэрбум төгрөгөөр, төсвийн нийт зарлага 41.3 хувь буюу 2,935.5 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдэж, төсвийн зарлагын өсөлт орлогын өсөлтөөс 0.7 пунктээр бага гарсан нь нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл ашигтай гарч өмнөх оны мөн үетэй харьцуулахад 632.7 тэрбум төгрөгөөр сайжрахад нөлөөлжээ.

Хүснэгт 1. Нэгдсэн төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр

Тэрбум төгрөгөөр

Алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр	ӨО-ны мөн үед	2024 оны эхний 5 сарын гүйцэтгэл			
		Төл.	Гүйц.	Хувь.	Зөрүү
Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-980.3	1,911.3	-1,977.1	-103.4	-3,885.5
Засгийн газрын бонд	-646.0	-1,423.4	-603.0	42.4	820.3
Засгийн газрын зээл	230.5	746.5	552.0	74.0	-194.5
Тогтвортжуулалтын сангийн хуримтлагдсан үлдэгдэл	0.0	0.0	0.0	0.0	0.0
Өмч хувьчлал	0.5	0.00	0.10	0.0	0.10
НИЙТ ДҮН	-1,395.3	1,234.4	-2,028.0	-164.3	-3,262.5

Эх сурвалж: Сангийн яам

2024 оны эхний 5 сарын гүйцэтгэлээр гадаад төслийн зээлийн үндсэн төлбөрт 463.8 тэрбум төгрөг төлсөн бол 1,015.8 тэрбум төгрөгийн гадаад төслийн зээл шинээр авч, 102.8 сая төгрөгийн өмч хувьчлалын орлогыг төвлөрүүлж, урт хугацаат дотоод бондын үндсэн төлбөрт 30.0 тэрбум төгрөг төлсөн ба гадаад бондын үндсэн төлбөрт 573.0 тэрбум төгрөг төлсөн байна.

Нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого 12,072.0 тэрбум төгрөг болж, өнгөрсон оны мөн үеэс 42.0 хувь дуюу 3,568.2 тэрбум төгрөгөөр, орлогын төлөвлөгөө 0.7 хувь дуюу 82.5 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрсөн байна.

”

2. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого

Нийт тэнцвэржүүлсэн орлогын төлөвлөгөөний биелэлтийг төсвийн шатлал бүрээр авч үзвэл улсын төсөв 1.3 хувь буюу 114.7 тэрбум төгрөгөөр, орон нутгийн төсөв 0.8 хувь буюу 20.1 тэрбум төгрөгөөр, эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв 7.7 хувь буюу 66.2 тэрбум төгрөгөөр, нийгмийн даатгалын сан 1.7 хувь буюу 39.9 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс тус тус дутуу төвлөрчээ.

Өнгөрсон оны мөн үетэй харьцуулахад эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв 27.0 хувь буюу 168.9 тэрбум төгрөгөөр, улсын төсөв 41.5 хувь буюу 2,464.8 тэрбум төгрөгөөр, нийгмийн даатгалын сан 51.6 хувь буюу 795.7 тэрбум төгрөгөөр, орон нутгийн төсөв 82.0 хувь буюу 1,194.6 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.


Хүснэгт 2. Нэгдсэн төсвийн орлогын 2024 оны эхний 5 сарын гүйцэтгэл, төсвийн шатлалаар

Тэрбум төгрөгөөр

Ангилал	Улсын төсөв		Орон нутгийн төсөв		НДС		ЭМДС	
	Төл.	Гүйц.	Төл.	Гүйц.	Төл.	Гүйц.	Төл.	Гүйц.
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	9,087.5	9,055.9	2,671.6	2,651.5	2,377.1	2,337.2	861.5	795.3
ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН	191.7	192.9	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	8,512.9	8,398.2	2,671.6	2,651.5	2,377.1	2,337.2	861.5	795.3
Татварын орлого	7,537.4	7,455.6	2,109.6	2,134.5	1,673.6	1,633.7	861.5	795.3
Орлогын албан татвар	1,969.3	2,018.7	1,715.7	1,792.8	0.0	0.0	0.0	0.0
Нийгмийн даатгалын орлого	0.0	0.0	0.0	0.0	1,673.6	1,633.7	861.5	795.3
Хөрөнгийн албан татвар	0.0	0.0	161.7	164.2	0.0	0.0	0.0	0.0
Нэмэгдсэн өргтгийн албан татвар	2,402.0	2,257.4	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Онцгой албан татвар	407.1	436.1	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Тусгай зориулалтын орлого	10.9	10.5	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Гадаад үйл ажиллагааны орлого	750.8	659.3	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Бусад татвар, төлбөр, хураамж	1,997.2	2,073.7	232.2	177.5	0.0	0.0	0.0	0.0
Татварын бус орлого	975.5	942.6	562.1	517.0	703.5	703.5	0.0	0.0
Нийтлэг татварын бус орлого	357.9	445.1	190.5	158.5	0.0	0.0	0.0	0.0
Хөрөнгийн орлого	0.0	0.0	2.8	1.2	0.0	0.0	0.0	0.0
Тусlamжийн орлого	140.9	151.0	10.5	1.2	703.5	703.5	0.0	0.0
Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	476.7	346.5	358.3	356.2	0.0	0.0	0.0	0.0

Эх сурвалж: Сангийн яам

График 2. Нэгдсэн төсвийн орлогын бүтэц /Хувиар/



Нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлогын 93.8 хувийг татварын орлого, 6.2 хувийг татварын бус орлого эзэлж байна.

“


Татварын орлого 11,318.1 тэрбум төгрөг болж, орлогын төлөвлөгөө 1.2 хувь буюу 135.5 тэрбум төгрөгөөр бүурсан байна.

”

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад татварын орлого 40.1 хувь буюу 3,241.1 тэрбум төгрөгөөр, татварын бус орлого 76.6 хувь буюу 327.0 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Татварын орлогын 33.7 хувийг орлогын албан татвар, 15.3 хувийг нийгмийн даатгалын орлого, 1.5 хувийг хөрөнгийн албан татвар, 19.9 хувийг нэмэгдсэн өргтийн албан татвар, 3.9 хувийг онцгой албан татвар, 0.1 хувийг тусгай зориулалтын орлого, 5.8 хувийг гадаад үйл ажиллагааны орлого, 19.9 хувийг бусад татвар, төлбөр, хураамжийн орлого бүрдүүлж байна.

График 3. Татварын орлого /Тэрбум төгрөгөөр/



Тайлант хугацаанд татварын орлого төлөвлөснөөс 1.2 хувь буюу 135.5 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрөхөд нэмэгдсэн өргтийн албан татвар 6.0 хувиар (144.7 тэрбум төгрөг), гадаад үйл ажиллагааны орлого 12.2 хувиар (91.5 тэрбум төгрөг), нийгмийн даатгалын орлого 4.4 хувиар (78.6 тэрбум төгрөг) тус тус төлөвлөснөөс дутуу төвлөрсөн нь нөлөөлжээ.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2024 оны эхний 5 сарын гүйцэтгэлээр татварын орлого 40.1 хувь буюу 3,241.1 тэрбум төгрөгөөр өсөхөд орлогын албан татвар 70.4 хувь (1,574.2 тэрбум төгрөг)-аар, нийгмийн даатгалын орлого 21.1 хувь (301.6 тэрбум төгрөг), хөрөнгийн албан татвар 46.2 хувь (51.9 тэрбум төгрөг), нэмэгдсэн өргтийн албан татвар 30.9 хувь (532.7 тэрбум төгрөг), гадаад үйл ажиллагааны орлого 18.0 хувь (100.5 тэрбум төгрөг)-аар тус тус өссөн нь нөлөөлжээ.

“


Татварын бус орлого 753.9 тэрбум төгрөгт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 327.0 тэрбум төгрөгөөр, төлөвлөснөөс 53.0 тэрбум төгрөг буюу 7.6 хувиар өссөн байна.

”

Төлөвлөгөөтэй харьцуулахад хүүгийн орлого 36.3 тэрбум төгрөгөөр, торгуулийн орлого 19.8 тэрбум төгрөгөөр, төсөвт байгууллагын өөрийн орлого 50.4 тэрбум төгрөгөөр тус тус давж биелжээ.

Харин төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого 1.6 тэрбум төгрөгөөр, навигацийн орлого 72.0 тэрбум төгрөгөөр тус тус төлөвлөснөөс дутуу төвлөрсөн байна.

График 4. Татварын бус орлогын бүтэц /Хувиар/



Татварын бус орлогын 80.1 хувийг нийтлэг татварын бус орлого, 19.8 хувийг тусlamжийн орлого, 0.2 хувийг хөрөнгийн орлого эзэлж байна.

Нийтлэг татварын бус орлогыг бүрдүүлэгч эх үүсвэрүүдийг бүтцийн хувьд авч үзвэл 11.5 хувийг хүүгийн орлого, 14.4 хувийг торгуулийн орлого, 20.8 хувийг газрын тосны орлого, 41.3 хувийг төсөвт байгууллагын өөрийн орлого, 0.3 хувийг түрээсийн орлого эзэлсэн бол 11.6 хувийг бусад орлого бүрдүүлж байна.

“

Өнгөрсөн оны мөн үетэй харьцууллахаа нэгдсэн төсвийн нийт зарлага 2,935.5 тэрбум төгрөг буюу 41.3 хувьшар өссөн байна.

”

Хүснэгт 4. Нэгдсэн төсвийн зарлагын 2024 оны эхний 5 сарын гүйцэтгэл /төсвийн шатлалаар/

Тэрбум төгрөгөөр

Зардлын зүйл	Улсын төсөв		Орон нутгийн төсөв		НДС		ЭМДС	
	Төл.	Гүйц.	Төл.	Гүйц.	Төл.	Гүйц.	Төл.	Гүйц.
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	9,011.0	7,631.9	3,646.7	1,644.8	2,094.1	1,997.7	905.8	879.7
НИЙТ ЗАРЛАГА	8,819.5	7,414.2	3,615.9	1,641.0	2,110.9	1,998.4	905.8	880.8
УРСГАЛ ЗАРДАЛ	7,531.1	6,316.4	1,909.9	1,282.8	2,110.9	1,998.4	905.8	880.8
Бараа, ажил, үйлчилгээний зардал	3,498.4	2,772.6	1,143.5	784.9	0.8	0.1	7.3	6.2
Зээлийн үйлчилгээний төлбөр	662.9	516.1	10.5	8.8	0.0	0.0	0.0	0.0
Татаас	934.7	860.3	168.6	105.0	0.0	0.0	0.0	0.0
Ургал шилжүүлэг	2,435.0	2,167.3	587.3	384.1	2,110.1	1,998.3	898.5	874.6
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,288.4	1,097.8	1,705.9	358.2	0.0	0.0	0.0	0.0
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	191.4	217.7	30.8	3.9	-16.8	-0.7	0.0	-1.1
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-488.0	766.3	-975.0	1,006.7	283.0	339.5	-44.3	-84.4

Эх сурвалж: Сангийн яам

Тайлант хугацаанд төлөвлөснөөс улсын төсвийн зарлага 1,379.0 тэрбум, орон нутгийн төсвийн зарлага 2,001.9 тэрбум, нийгмийн даатгалын сангийн зарлага 96.4 тэрбум, эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага 26.1 тэрбум төгрөгөөр тус тус дутуу зарцуулагджээ.

Нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн өнгөрсөн оны мөн үеэс 41.3 хувь буюу 2,935.5 тэрбум төгрөгөөр өсөхөд ургал зардал 2,179.2 тэрбум, хөрөнгийн зардал 526.1 тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь нөлөөлжээ.

“

Зээлийн үйлчилгээний төлбөр өнгөрсөн оны мөн үетэй харьцууллахаад 29.1 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн бол тайлант хугацааны төлөвлөсөн дунгээс 22.1 хувь буюу 148.5 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулалттай гарсан байна.

”

3. Нэгдсэн төсвийн нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээл

Тайлант хугацаанд нэгдсэн төсвийн нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлд 13,388.9 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөсний 75.0 хувийг зарлагадаж 3,344.9 тэрбум төгрөгийг дутуу зарцуулжээ.

Хүснэгт 5. Нэгдсэн төсвийн нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн гүйцэтгэл /зардлын эдийн засгийн ангиллаар/

Тэрбум төгрөгөөр

ҮЗҮҮЛЭЛТ	Ө0-ны мөн үе	2024 оны эхний 5 сарын гүйцэтгэл			
		Төл.	Гүйц.	Хувь	Зөрүү
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	7,108.5	13,388.9	10,043.9	-25.0	-3,344.9
НИЙТ ЗАРЛАГА	7,118.7	13,183.4	9,824.1	-25.5	-3,359.3
УРСГАЛ ЗАРДАЛ	6,188.8	10,189.1	8,368.1	-17.9	-1,821.0
БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,654.9	4,414.2	3,354.1	-24.0	-1,060.2
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	770.7	2,276.0	2,023.9	-11.1	-252.1
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	179.1	279.9	235.3	-15.9	-44.6
Хангамж, бараа материалын зардал	67.9	128.1	101.4	-20.8	-26.7
Нормативт зардал	108.0	176.0	116.9	-33.6	-59.0
Эд хогшил, урсгал засварын зардал	32.9	128.8	57.7	-55.2	-71.1
Томилолт, зочны зардал	13.0	40.3	21.5	-46.6	-18.8
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	321.4	754.8	400.7	-46.9	-354.1
Бараа үйлчилгээний бусад зардал	162.0	630.4	396.6	-37.1	-233.8
XYY	495.8	673.4	524.9	-22.1	-148.5
ТАТААС	210.3	399.8	261.8	-34.5	-138.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,827.9	4,701.6	4,227.3	-10.1	-474.3
Засгийн газрын урсгал шилжүүлэг	1,353.7	1,100.6	994.8	-51.4	-1,538.3
Бусад урсгал шилжүүлэг	2,474.2	3,601.0	3,232.5	0.4	14.4
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	929.9	2,994.3	1,456.0	-51.4	-1,538.3
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	-10.3	205.5	219.8	7.0	14.4


Эх сурвалж: Сангийн яам

“Нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дунд урсгал зардлын эзлэх хувийн жин 83.3 хувьд хүрч, онгөрсөн оны мөн үеэс 3.7 түшкээр нэмэгдсэн байна.”

График 5. Урсгал зардлын бүтэц /Хувиар/

Нэгдсэн төсвийн нийт зарлагын 83.3 хувь буюу 8,368.1 тэрбум төгрөг нь урсгал зардал бөгөөд нийт урсгал зардлын 50.5 хувийг урсгал шилжүүлэг, 40.1 хувийг бараа, ажил үйлчилгээний зардал, 6.3 хувийг зээлийн үйлчилгээний төлбөр, 4.8 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж, 3.1 хувийг татаас тус тус эзэлж байна.

ОНГӨРСӨН ОНЫ МӨН ҮЕТЭЙ ХАРЬЦУУЛАХАД НЭГДСЭН ТӨСВИЙН УРСГАЛ ЗАРДАЛ 2,179.2 ТЭРБУМ ТӨГРӨГӨӨР НЭМЭГДСЭН БАЙНА. ҮҮнд: бараа, ажил үйлчилгээний зардал 1,699.2 тэрбум төгрөгөөр, цалин хөлс болон нэмэгдэл урамшил 1,253.2 тэрбум төгрөгөөр, урсгал шилжүүлэг 399.4 тэрбум төгрөгөөр, зээлийн үйлчилгээний төлбөр 29.1 тэрбум төгрөгөөр, татаас 51.5 тэрбум төгрөгөөр, эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл 230.1 тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь голлон нөлөөлжээ.



“Монгол Улсын 2024 оны төсвийн түхай хуулиар 39 төсвийн ерөнхийлөн захирагчдын төсөв зарцууллах эрхийг баталсан бөгөөд 2024 оны эхний 5 сарын гүйцэтгэлээр цэсийн төсвийн нийт зарлага 3,343.9 тэрбум төгрөгөөр дутчуу зарцуулагдаж 75.0 хувийн гүйцэтгэлтэй гарчээ.”

Төсвийн ерөнхийлөн захирагчдын нийт зарлагын 16.4 хувийг Сангийн сайдын багц, 14.0 хувийг Боловсрол, шинжлэх ухааны сайдын багц, 10.4 хувийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багц, 1.2 хувийг Эрүүл мэндийн сайдын багц, 4.7 хувийг Хууль зүй, дотоод хэргийн сайдын багц, үлдэх 53.3 хувийг бусад төсвийн ерөнхийлөн захирагчдын зардал эзэлж байна.

Хүснэгт 6. Улсын төсвийн нийт зардал, төсвийн ерөнхийлөн захирагчаар

Сая төгрөгөөр

Төсвийн ерөнхийлөн захирагч	2024 оны эхний 5 сарын гүйцэтгэл			
	Төл.	Гүйц.	Зөрүү	Хувь
Монгол Улсын Ерөнхийлөгч	11,942.4	7,039.0	-4,903.41	58.9
Улсын Их Хурлын дарга	44,614.5	32,449.3	-12,165.17	72.7
Үндсэн хуулийн цэцийн дарга	1,476.2	1,322.3	-153.92	89.6
Улсын дээд Шүүхийн ерөнхий шүүгч	6,914.3	4,967.4	-1,946.85	71.8
Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга	52,713.1	39,810.1	-12,902.97	75.5
Улсын ерөнхий прокурор	36,205.6	29,271.5	-6,934.03	80.8
Үндэсний аюулгүй байдлын зөвлөл	10,896.5	10,427.4	-469.08	95.7
Монгол Улсын Ерөнхий сайд	173,933.9	99,901.4	-74,032.52	57.4
Монгол Улсын Шадар сайд	126,443.1	87,364.8	-39,078.27	69.1
Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга	41,516.8	22,367.1	-19,149.75	53.9
Сангийн сайд	2,073,145.7	1,646,991.0	-426,154.70	79.4
Хууль зүй, дотоод хэргийн сайд	547,684.2	469,173.2	-78,511.00	85.7
Байгаль орчин, аялал жуулчлалын сайд	88,548.4	50,055.3	-38,493.11	56.5
Батлан хамгаалахын сайд	232,574.7	190,256.8	-42,317.84	81.8
Боловсрол, шинжлэх ухааны сайд	1,595,239.6	1,405,468.9	-189,770.71	88.1
Гадаад харилцааны сайд	83,641.9	51,030.3	-32,611.58	61.0
Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд	9,548.2	6,807.3	-2,740.93	71.3
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	209,348.0	163,022.2	-46,325.86	77.9
Эрүүл мэндийн сайд	195,545.3	121,519.3	-74,025.94	62.1
Төрийн албаны зөвлөлийн дарга	3,015.5	1,424.9	-1,590.62	47.3
Сонгуулийн ерөнхий хорооны дарга	23,861.4	7,815.5	-16,045.90	32.8
Хүний эрхийн үндэсний хорооны дарга	1,974.9	1,848.2	-126.78	93.6
Монгол Улсын ерөнхий аудитор	15,124.9	12,564.2	-2,560.72	83.1
Санхүүгийн зохицуулах хорооны дарга	5,136.4	3,765.4	-1,370.98	73.3
Үндэсний Статистикийн газрын дарга	8,393.5	6,944.8	-1,448.68	82.7
ЦАУЗБҮК-ын дарга	7,822.2	7,767.9	-54.29	99.3
Зам, тээврийн хөгжлийн сайд	65,613.0	37,024.1	-28,588.96	56.4
Барилга, хот байгуулалтын сайд	48,893.0	46,830.5	-2,062.44	95.8
Эрчим хүчний сайд	117,711.0	90,640.6	-27,070.34	77.0
Авлигатай тэмцэх газар	22,926.1	15,237.0	-7,689.11	66.5
Соёлын сайд	108,466.5	90,858.5	-17,608.03	83.8
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	1,161,114.7	1,047,861.3	-113,253.36	90.2
Нийслэл Уб хотын авто замын түгжрэлийг бууруулах үндэсний хороо	27,931.2	27,931.2	0.00	100.0
Шүүхийн сахилгын хорооны дарга	1,704.5	1,167.2	-537.37	68.5
Эдийн засаг, хөгжлийн сайд	9,108.6	5,489.0	-3,619.67	60.3
Цахим хөгжил, харилцаа холбооны сайд	29,063.9	15,879.6	-13,184.33	54.6
Олимп, нийтийн биеийн тамир, спортын үндэсний хороо дарга	50,725.7	35,872.1	-14,853.58	70.7
Боомтын сэргэлтийн үндэсний хороо дарга	3,548.3	2,855.2	-693.08	80.5
НИЙТ ЗАРДАЛ	7,254,067.6	5,899,021.7	-1,355,045.88	81.3

Эх сурвалж: Сангийн яам

2024 оны эхний 5 сарын гүйцэтгэлээр 308.4 тэрбум төгрөгийг зарцуулж 99.5 хувийн гүйцэтгэлтэй гарчээ.

4. Улсын төсвийн хөрөнгө оруулалт

Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардалд 2024 онд нийт 3,359.4 тэрбум төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ. 2024 оны эхний 5 сарын гүйцэтгэлээр 308.4 тэрбум төгрөгийг зарцуулж 99.5 хувийн гүйцэтгэлтэй гарчээ.

Хүснэгт 7. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийн гүйцэтгэл
/Төсвийн ерөнхийлөн захирагчаар/

Сая төгрөгөөр


Хуулийн дугаар	ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ	2024 оны төсөв	2024 оны эхний 5 сарын гүйцэтгэл			
			Төл.	Гүйц.	Зөрүү	Хувь
I	МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА	22,089.6	2,702.5	2,702.5	0.00	100.0
II	МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД	1,200.0	-	-	-	-
III	МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД	25,687.7	-	-	-	-
IV	МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙД	44,000.0	1,403.4	1,403.4	0.0	100.0
V	МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА	51,391.4	2,077.4	2,077.4	88.0	100.0
VI	БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД	36,937.3	35.0	35.0	26.0	100.0
VII	БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД	20,015.3	2,468.8	2,468.8	61.0	100.0
VIII	ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД	13,700.0	5,391.9	5,391.9	-	100.0
IX	САНГИЙН САЙД	224,776.2	11,187.3	11,187.3	222.9	100.0
X	ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД	127,187.7	22,464.6	22,386.3	78.3	99.7
XI	ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД	48,758.1	8,134.7	8,134.7	0.0	100.0
XII	БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД	405,293.0	39,342.3	39,342.3	0.0	100.0
XIII	БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД	744,870.7	89,498.5	88,056.4	1,442.2	98.4
XIV	СОЁЛЫН САЙД	154,881.0	11,653.8	11,653.8	625.0	100.0
XV	ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД	612,006.5	19,652.0	19,652.0	358.0	100.0
XVI	ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХҮЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД	123,588.3	4,019.7	4,019.7	0.0	100.0
XVII	ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД	224,286.0	37,928.0	37,928.0	834.6	100.0
XVIII	ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД	281,079.0	45,701.1	45,701.1	0.0	100.0
XIX	АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ДАРГА	2,658.2	113.6	113.6	50.0	100.0
XX	УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ШҮҮГЧ	11,528.8	-	-	-	-
XXI	ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛ	19,825.0	-	-	-	-
XXII	УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР	11,348.3	4,941.8	4,941.8	-	100.0
XXIII	МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР	881.1	-	-	-	-
XXIV	САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА	892.5	-	-	-	-
XXV	ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЙД	16,423.0	339.6	339.6	91.0	100.0
XXVI	МОНГОЛ УЛСЫН САЙД, ОЛИМП, НИЙТИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДАРГА	72,353.4	9,887.2	9,887.2	0.0	100.0
XXVII	МОНГОЛ УЛСЫН САЙД, БООМТЫН СЭРГЭЛТИЙН ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДАРГА	5,463.1	1,137.0	1,137.0	-	100.0
XXVIII	"МОНГОЛ УЛСЫН САЙД, НИЙСЛЭЛ УЛААНБААТАР ХОТЫН АВТОЗАМЫН ТҮГЖРЭЛИЙГ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДАРГА"	56,229.2	27,931.2	27,931.2	-	100.0
	НИЙТ	3,359,350.3	309,934.8	308,414.3	1,520.5	99.5

Эх сурвалж: Сангийн яам



5. Нийгмийн даатгалын сан

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА

/Тэрбум төгрөгөөр/



НИЙГМИЙН ДААТГАЛЫН САН




-Өөрчлөлт (Өнгөрсөн оны мөн үес)

Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээний газрын
Төсвийн хяналт, шинжилгээний хэлтэс

Нийгмийн даатгалын сангийн зарлагад 1,997.7 тэрбум төгрөгийг зарцуулсан нь өнгөрсөн оны мөн үеэс 500.0 тэрбум төгрөг буюу 33.4 хувиар өссөн байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад тэтгэврийн даатгалын сангийн зарлага 482.3 тэрбум төгрөгөөр, тэтгэмжийн даатгалын сангийн зарлага 8.6 тэрбум төгрөгөөр, ҮОМШӨ-ий даатгалын сангийн зарлага 1.9 тэрбум төгрөгөөр, ажилгүйдлийн даатгалын сангийн зарлага 8.6 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

2024 оны эхний 5 сарын гүйцэтгэлээр нийгмийн даатгалын санд нийт 2,337.2 тэрбум төгрөгийн орлого төвлөрсөн нь төлөвлөснөөс 1.7 хувь буюу 39.9 тэрбум төгрөгөөр дутуу биелэн орлогын гүйцэтгэл 39.7 хувьтай гарсан байна.

График 6. Нийгмийн даатгалын сангийн нийт зарлагын бүтэц /Хувиар/




6. Эрүүл мэндийн даатгалын сан

“

Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөө 7.7 хувиар дутуу биелжээ.

”

График 7. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого /Тэрбум төгрөгөөр/




Эрүүл мэндийн даатгалын санд 2024 оны эхний 5 сарын гүйцэтгэлээр 795.3 тэрбум төгрөгийн орлого төвлөрсөн нь төлөвлөснөөс 7.7 хувь буюу 66.2 тэрбум төгрөгөөр дутуу биелсэн байна.

“

Эрүүл мэндийн даатгалын сангаас 905.8 тэрбум төгрөгийн зарлага хийгдэж өнгөрсөн оны мөн үеэс 206.4 тэрбум төгрөгөөр өссөн байна.

”

График 8. Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага /Тэрбум төгрөгөөр/



2024 оны эхний 5 сарын гүйцэтгэлээр эрүүл мэндийн даатгалын сангаас 905.8 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөж, 879.7 тэрбум төгрөгийг зарцуулж, тус сангийн гүйцэтгэл 97.1 хувьтай гарчээ. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад тус сангийн нийт зарлага 206.4 тэрбум төгрөгөөр өссөн байна.

2024 оны эхний 5 сарын гүйцэтгэлээр орон нутгийн төсвийн зарлага 2,001.9 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулагдсан байна.

7. Орон нутгийн төсөв

2024 оны эхний 5 сарын гүйцэтгэлээр орон нутгийн төсвийн орлого 2,651.5 тэрбум төгрөг болж төлөвлөсөн дүнгээс 0.8 хувь буюу 20.1 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрсөн бол орон нутгийн төсвийн нийт зарлага 1,644.8 тэрбум төгрөг болж төлөвлөсөн 54.9 хувь буюу 2,001.9 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулагдаж, орон нутгийн төсвийн тэнцэл 1,006.7 тэрбум төгрөгийн ашигтай гарчээ.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад орон нутгийн төсвийн орлого 82.0 хувиар буюу 1,194.6 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн бол, орон нутгийн төсвийн нийт зарлага 74.6 хувь буюу 702.9 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Орон нутгийн төсвийн нийт орлогын 86.6 хувийг орон нутгийн төсвийн орлого, 7.0 хувийг улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг, 6.5 хувийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн орлогын шилжүүлэг тус тус эзэлж байна. Улсын төсвөөс орон нутгийн төсөвт 184.9 тэрбум төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгохоор төлөвлөгдөж 100 хувийн гүйцэтгэлтэй, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн орлогын шилжүүлэгт 173.4 тэрбум төгрөгийг шилжүүлэхээр төлөвлөгдөж 98.8 хувийн гүйцэтгэлтэй тус тус гарсан байна.

Хүснэгт 8. Аймгуудад улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг, орон нутгийн хөгжлийн сангийн шилжүүлэг


Сая төгрөгөөр

АЙМАГ	САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ			ОН-ИЙН ХӨГЖЛИЙН НЭГДСЭН САНГИЙН ОРЛОГЫН ШИЛЖҮҮЛЭГ		
	Олгох	Олгосон	Хувь	Олгох	Олгосон	Хувь
Архангай	17,324.0	17,324.0	100.0	4,393.4	4,343.2	98.9
Баян-Өлгий	10,801.2	10,801.2	100.0	4,113.8	4,090.7	99.4
Баянхонгор	19,009.0	19,009.0	100.0	7,345.9	7,212.6	98.2
Булган	4,612.7	4,612.7	100.0	4,887.4	4,865.9	99.6
Говь-Алтай	17,330.1	17,330.1	100.0	5,898.4	5,865.9	99.4
Дорноговь	-	-	0.0	14,729.8	14,193.7	96.4
Дорнод	-	-	0.0	8,905.1	8,649.3	97.1
Дундговь	11,267.1	11,267.1	100.0	5,356.6	5,333.9	99.6
Завхан	15,788.9	15,788.9	100.0	5,069.9	5,035.9	99.3
Өвөрхангай	13,779.4	13,779.4	100.0	5,007.2	4,923.5	98.3
Өмнөговь	-	-	0.0	16,240.3	15,808.3	97.3
Сүхбаатар	6,523.0	6,523.0	100.0	6,275.8	6,250.4	99.6
Сэлэнгэ	-	-	0.0	9,588.5	9,479.0	98.9
Төв	8,225.7	8,225.7	100.0	9,726.0	9,697.9	99.7
Увс	14,226.7	14,226.7	100.0	4,507.0	4,444.7	98.6
Ховд	6,256.1	6,256.1	100.0	10,164.8	10,124.0	99.6
Хөвсгөл	19,173.7	19,173.7	100.0	5,807.6	5,761.0	99.2
Хэнтий	17,367.7	17,367.7	100.0	6,385.1	6,350.1	99.5
Дархан-Уул	-	-	0.0	7,204.9	7,186.6	99.7
Улаанбаатар	-	-	0.0	17,370.7	17,265.4	99.4
Орхон	-	-	0.0	12,023.8	12,005.7	99.8
Говьсүмбэр	3,228.5	3,228.5	100.0	2,420.6	2,408.5	99.5
ДҮН	184,913.7	184,913.7	100.0	173,422.7	171,295.9	98.8

Эх сурвалж: Сангийн яам

Орон нутгийн нийт орлого төлөвлөснөөс 20.1 тэрбум төгрөг буюу 0.8 хувиар дутуу төвлөрсөн нь орон нутгийн татварын бус орлого 8.0 хувь буюу 45.0 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрсөнтэй холбоотой байна.

График 9. Орон нутгийн төсвийн орлогын бүтэц /Хувиар/



Орон нутгийн орлогыг аймгуудаар харуулбал: Өмнөговь аймаг 34,467.6 сая, Дархан-Уул аймаг 8,898.6 сая, Хөвсгөл аймаг 8,150.1 сая, Төв аймаг 8,704.5 сая, Булган аймаг 8,399.1 сая, Завхан аймаг 5,614.3 сая, Хэнтий аймаг 5,143.0 сая, Архангай аймаг 4,376.2 сая, Увс аймаг 4,225.7 сая, Өвөрхангай аймаг 3,359.4 сая, Сэлэнгэ аймаг 3,578.8 сая, Говь-Алтай аймаг 1,855.6 сая, Говьсүмбэр аймаг 1,495.3 сая, Дундговь аймаг 1,598.0 сая, сая төгрөгөөр төлөвлөгөөг давуулан биелүүлсэн бол Дорнговь аймаг 11,635.0 сая, Дорнод аймаг 1,755.2, Сүхбаатар аймаг 6,876.6 сая, Орхон аймаг 19,023.9 сая, Ховд аймаг 521.6, Улаанбаатар хот 79,236.8 сая төгрөгөөр тус тус төлөвлөснөөс дутуу төвлөрүүлсэн байна.